*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*2 дугаар хавсралт*

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН БОЛОВСРОЛЫНАСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ГЭСЭРМААГИЙН МӨНГӨНЧИМЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Стратегийн зорилго 1. Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ. | | | | | | | |
| **Зорилт 1**. Боловсролын салбарын хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах. | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1**<br>Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө. | Арга хэмжээ хүүхдийн тоо | 37 цэцэрлэгт 25234 хүүхэд хамрагдсан. | 2 | 4 | 01 | 12 |
| 2. | **Арга хэмжээ 1.2**<br>Ерөнхий боловсролын сургуулиудад интерактив цахим хичээл явуулах програм хангамж, дэд бүтцийн боломжийг бүрдүүлнэ | Арга хэмжээний тоо | Интерактив цахим хичээлд 19 сургуулийн 3-4, 5-6, 10-12 дугаар ангийн сурагчдыг хамруулсан. | 2 | 4 | 01 | 12 |
| 3 | **Арга хэмжээ 1.3**<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүртгэл, элсэлтийг цахимаар зохион байгуулна. | Элсэлтийн үйл ажиллагаа цахимаар зохион байгуулах, хэрэгжилтийн хувь | 23 сургуулийн 1 дүгээр ангийн 4702 хүүхэд, 136 цэцэрлэгийн 2-5 насны 25,234 хүүхдийн хамруулсан. | 100% | Нэмэлт бүртгэлийн хүлээн авна. | 8 | 11 |
| Стратегийн зорилго 2. Хяналт-шинжилгээний үр дүнд тулгуурлан бодлого, шийдвэрийн төлөвлөлт, зохицуулалтыг хийж хэвшинэ | | | | | | | |
| 1. **Зорилт 2.** Боловсролын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих. | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1**<br>Төсвийн ерөнхийлөн захирагчтай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай хариуцлагын гэрээ байгуулах, гэрээний биелэлт, тайланг үнэлэх ажлыг зохион байгуулна. | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - | 01 | 06 |
| 2. | **Арга хэмжээ 2.2**<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх, чадварлаг | Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо, | 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 3 | 8 | 01 | 12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | багш нарыг урамшуулах, дэмжих, тэдний тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Багш" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 3. | **Арга хэмжээ 2.3** Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд гадаад, дотоодын тэмцээн уралдаан, сургалт, ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулах төсөл, арга хэмжээг шалгаруулан хэрэгжүүлнэ. | Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо | 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 1 | 2 | 01 | 12 |
| 4. | **Арга хэмжээ 2.4** Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийнэ. | Арга хэмжээ тоо | 2 | 1 | 2 | 01 | 12 |
| | **Арга хэмжээ 2.5** Багш, сурагчдын дунд дүүргийн аварга шалгаруулах олимпиадуудыг зохион байгуулна. | Арга хэмжээ, хамрагдах хүүхдийн тоо | Математик, физик, химийн 2 удаагийн олимпиадыг зохион байгуулж 10,000 гаруй сурагчид хамрагдсан. | 1 | 2 | 3 | 12 |
| | **Арга хэмжээ 2.6** Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна. | Хэрэгжсэн төсөл, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн тоо | 10 | 3 | 5 | 01 | 12 |
| | **Арга хэмжээ 2.7** Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Боловсролын үйлчилгээнд хамрагдсан тусгай хэрэгцээт хүүхдийн тоо, зохион байгуулсан сургалтын тоо | Ерөнхий боловсролын 23 сургуулийн 520, сургуулийн өмнөх боловсролын 33 байгууллагад 160, нийт 680 хүүхдийг хамруулсан. | 2-оос доошгүй сургалтад 200 багш, сурагчийг хамруулна. | 3-оос доошгүй сургалтад 300 багш, сурагчийг хамруулна. | 01 | 12 |
| | Стратегийн зорилго 4. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, дэвшилтэт технологид суурилан түргэн шуурхай хүргэнэ. | | | | | | |
| | **Зорилт 3.** Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1** Албан хэрэг хөтлөлтийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, ERP програмын хэрэглээг хэвшүүлэн иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд нь чанартай шийдвэрлэнэ. | Шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | 100 | 01 | 12 |
| 2. | **Арга хэмжээ 3.2** Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, баримт бичгийг боловсруулах, зохион байгуулах MNS5140:2011 стандартыг мөрдөн байгууллагын архивт хүлээлгэн өгнө. | Хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгжийн тоо | 5 | 5 | - | 01 | 12 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Арга хэмжээ 3.3** Ажлын цаг, цаг ашиглалтын зөрчилгүй ажиллана. | Цаг ашиглалтын хувь | 100% | 100% | 100% | 01 | 12 |
| 4. | **Арга хэмжээ 3.4** Төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан мөрдөж ажиллана. | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | 100% | 01 | 12 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** Дээд шатны байгууллага болон Засаг даргын Тамгын газар, холбогдох сургалтын байгууллагаас зохион байгуулсан сургалтад идэвхтэй хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | 5 | 2 | 3 | 01 | 12 |
| 2. | **Арга хэмжээ 1.2** Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан дүрэм, журмууд, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг танхим болон цахим хэлбэрээр судална. | Судалсан хууль, дүрмийн тоо | 3 | 2 | 2 | 01 | 12 |

**ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:**

БОЛОВСХОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН — Г.МӨНГӨНЧИМЭГ / ................ / — 2024.01.08

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Р.ЦЭВЭЭНДУЛАМ / ................ / — 2024.01.08

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*2 дугаар хавсралт*

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ГЭСЭРМААГИЙН МӨНГӨНЧИМЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Стратегийн зорилго 1. Холбогдогч талуудын оролцоо, судалгаа, шинжилгээ, баримтад үндэслэсэн бодлого, шийдвэрийг боловсруулж, төлөвлөж хэвшинэ. | | | | | | | |
| Зорилт 1. Боловсролын салбарын хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах. | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын түвшинг үе шаттайгаар өсгөнө. | Арга хэмжээ хүүхдийн тоо | 37 цэцэрлэгт 25234 хүүхэд хамрагдсан. | 2 | 2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын 134 байгууллагад 2-5 насны хүүхдүүдийг 2 үе шаттай Емонголиа цахим системээр бүртгэж, хүсэлт гаргасан 26067 хүүхдийг хамруулсан.<br>Түрээсийн 30 байранд 191 бүлгийн 4775 хүүхдийг хамруулсан.<br>Хан-Уул дүүргийн 4, 14 дүгээр хорооны 12, 165 дугаар цэцэрлэгт цомцог гэр, 15, 20, 25 дугаар хороонд 335, 336, 342 дугаар цэцэрлэг 880 хүүхдийн ороор хүчин чадал нэмэгдсэн. | 2024.01.02-2024.12.02 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 1.2** Ерөнхий боловсролын сургуулиудад интерактив цахим хичээл явуулах програм хангамж, дэд бүтцийн боломжийг бүрдүүлнэ | Арга хэмжээний тоо | Интерактив цахим хичээлд 19 сургуулийн 3-4, 5-6, 10-12 дугаар ангийн сурагчдыг хамруулсан. | 2 | Хан-Уул дүүргийн хэмжээнд Интерактив цахим хичээл явуулах танхимыг ашиглан 25 багш хамтран 21 цахим хичээл боловсруулж, ерөнхий боловсролын 23 сургууль 15 судлагдахуунаар 558 цахим даалгаврын санг бүрдүүлсэн.<br>2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 24 сургууль, 40 цэцэрлэгийн багш нар Мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажиллаж сургалтын хөтөлбөрийн хүрээнд цахим хичээл, даалгаврын сан бүрдүүлэн сурагчдыг бие даан суралцах боломжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд 28 | 2024.01.02-2024.12.02 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэргэжлийн хөгжлийн бүлэгт 97 бүлгийн гишүүд дүүргийн хэмжээнд сургалтын хөтөлбөрийн сан бүрдүүлэхэд хамтран ажиллаж байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр ерөнхий боловсролын 32 дугаар сургуульд мэдээлэл зүйн кабенитийг иж бүрэн тохижилт, 41 дүгээр сургуульд 5 ширхэг иж бүрэн компьютер, 60 дугаар сургуульд 5 ширхэг иж бүрэн компьютер, 7, 10, 26, 59, 89, 135, 156, 161, 163, 165 дугаар сургуулиудад 10 ширхэг иж бүрэн компьютер, ерөнхий боловсролын 23 сургууль, 40 цэцэрлэгийн багш нарт 841 ширхэг сүүлийн үеийн иж бүрэн зөөврийн компьютерийг олгох ажлыг зохион байгуулсан. | | |
| 3 | **Арга хэмжээ 1.3**<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүртгэл, элсэлтийг цахимаар зохион байгуулна. | Элсэлтийн үйл ажиллагаа цахимаар зохион байгуулах, хэрэгжилтийн хувь | 23 сургуулийн 1 дүгээр ангийн 4702 хүүхэд, 136 цэцэрлэгийн 2-5 насны 25,234 хүүхдийн хамруулсан. | 100% | 2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын 23 сургуульд 128 бүлэгт 5115 сурагч, төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 32 сургуулийн 2203 сурагч нийт 54 сургуульд 7318 сурагч нэгдүгээр ангид элсэн суралцсан.<br>2024-2025 оны хичээлийн жилд цэцэрлэгийн бүртгэл, элсэлтийг 2 үе шаттай Емонголиа цахим системээр зохион байгуулж төрийн өмчийн 40, төрийн бус өмчийн 94, нийт 134 цэцэрлэгт 26067 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна.<br>Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Боловсролын хэлтэст иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг үндэслэн хувийн цэцэрлэгийн төлбөрийг төлөх боломжгүй-1062, түр оршин суугчийн-2750, хөгжлийн бэрхшээлтэй-40, гадаад регистерийн дугаартай-10, нийт-3862 хүүхдийг төрийн өмчийн цэцэрлэгт уламжлалт системээр бүртгэж шийдвэрлэсэн. | 2024.01.02-2024.12.02 | 100% |
| Стратегийн зорилго 2. Хяналт-шинжилгээний үр дүнд тулгуурлан бодлого, шийдвэрийн төлөвлөлт, зохицуулалтыг хийж хэвшинэ | | | | | | | |
| **Зорилт 2.** Боловсролын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих. | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1**<br>Төсвийн ерөнхийлөн захирагчтай төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Төсвийн ерөнхийлөн захирагчтай төрийн өмчийн ерөнхий боловсролын 23 сургуулийн захирал, 40 цэцэрлэгийн эрхлэгч нартай хариуцлагын гэрээ байгуулах нь | 2024.01.02-2024.12.02 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цэцэрлэгийн эрхлэгч нартай хариуцлагын гэрээ байгуулах, гэрээний биелэлт, тайланг үнэлэх ажлыг зохион байгуулна. | | | | Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу (томилох, чөлөөлөх) Нийслэлийн Боловсролын газрын даргад эрх нь шилжсэн.<br>Ерөнхий боловсролын сургуулийн 23 захирал, 39 цэцэрлэгийн эрхлэгч нарын эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан хамгаалалтыг 2024 оны 06 дугаар сарын 6, 7-ны өдрүүдэд зохион байгуулсан. | | |
| 2. | **Арга хэмжээ 2.2**<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг хөгжүүлэх, чадварлаг багш нарыг урамшуулах, дэмжих, тэдний тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Багш” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо, | 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 3 | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/63 дугаар захирамжаар "Багш" дэд хөтөлбөрийг 2024 онд хэрэгжүүлэхэд 175.0 сая төгрөг батлагдсан. 1 дүгээр зорилтын хүрээнд 3 төсөл, арга хэмжээ, 3 дугаар зорилтын хүрээнд 3 төсөл, арга хэмжээ, нийт 6 төсөл, арга хэмжээг Засаг даргын зөвлөлийн хурлаар 114,9 сая төгрөгний санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Үүнд:<br>-Хан-Уул дүүргийн төрийн өмчийн сургуулиудын багш ажилчдын дундах 5 төрөлт тэмцээний төсөл (24,0) сая төгрөг:<br>-Япон Улсад эдийн засгийн хөгжил, технилоги, олон улсын хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтолцоотой танилцах, татварын бодлого зохицуулалтын талаар туршлага судлах төсөл (18,6) сая төгрөг:<br>-Нийслэлийн ерөнхий боловсролын 18 дугаар сургуулийн Биологийн кабинет байгуулах төсөл (11,9) сая төгрөг:<br>-БНСУ-д зохион байгуулагдах багш нарын ур чадварыг дээшлүүлэх, сургалтад оролцоож, туршлага судлах төсөл (36,0) сая төгрөг:<br>-Өвийн боловсролын сургагч багш бэлтгэх төсөл (8,8) сая төгрөг:<br>-Хятад Улсын эдийн засгийн хөгжил, сургалтын шинэлэг арга зүй, технологид суралцуулах, мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэх, харилцан сайн туршлага судлах төсөл (15,6) сая төгрөг | 2024.01.02-2024.12.02 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Арга хэмжээ 2.3**<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд гадаад, дотоодын тэмцээн уралдаан, сургалт, ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулах төсөл, арга хэмжээг шалгаруулан хэрэгжүүлнэ. | Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо | 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн. | 1 | 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын заах арга ур чадварыг нэмэгдүүлэх "Ур чадвар-2024"-ын уралдааныг 14 чиглэлээр ерөнхий боловсролын 58 сургуулийн 2872 багш, 40 цэцэрлэгийн 902 багш нарын дунд зохион байгуулж шилдгүүдээ шалгаруулсан.<br>-БНСУ-д зохион байгуулагдах багш нарын ур чадварыг дээшлүүлэх, туршлага судлах сургалтад 2024 оны 05 дугаар сарын 15-20-ны өдрүүдэд 8 багш,<br>-Хятад Улсын эдийн засгийн хөгжил, сургалтын шинэлэг арга зүй, технологид суралцуулах, мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэх, харилцан сайн туршлага судлах сургалтад 2024 оны 07 дугаар сарын 21-27-ны өдрүүдэд 16 багшийг хамруулсан. | 2024.01.02-2024.12.02 | 100% |
| 4. | **Арга хэмжээ 2.4**<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийнэ. | Арга хэмжээ тоо | 2 | 1 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог 23 сургууль 100 хувь нэвтрүүлж, хүүхдийг эрүүл баталгаат хоол хүнсээр хангаж байна. 21 сургуулиас 12 сургууль (18, 26, 32, 60, 75, 114, 118, 130, 135, 156, 165, 63) хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бие даан хэрэгжүүлж, 2024-2025 оны хичээлийн жилд шинээр хоол үйлдвэрлэлийг бие даан хэрэгжүүлэх ерөнхий боловсролын 6 (10, 52, 34, 115, 161 163) сургууль, 3 (15, 41, 89) сургууль түрээсээр гал тогоо ажиллуулж байна.<br>Мөн ерөнхий боловсролын 15, 34, 75, 115, 130 дугаар сургуулиуд "E-school" киоск машиныг сургууль дээрээ суурилуулж 1-5 дугаар ангийн 179 бүлгийн 7964 сурагчийн үдийн хоолонд хамрагдаж буй мэдээллийг тухай бүр оруулж байна.<br>-Боловсрол шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яамны хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн төлөвлөгөөт шалгалтыг 2024 оны 01-04 дүгээр сарын хооронд 67 сургууль, цэцэрлэгийн эрүүл ахуй, орчин, хоол | 2024.01.02-2024.12.02 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлдвэрлэл үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, зөвлөн туслах ажлуудыг зохион байгуулж гарсан зөрчил дутагдалд зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.<br>-Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газраас зохион байгуулсан "Хүнсний аюулгүй байдал" арга хэмжээний төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн байцаагч нартай Хоол үйлдвэрлэл үйлчилгээг бие даан болон түрээслэн хэрэгжүүлж байгаа төрийн өмчийн ерөнхий боловсролын 15 сургуулиар 2024 оны 04 дүгээр сарын 12-26-ны хооронд хяналт, шалгалт, зөвлөн туслахаар ажилласан.<br>-2024-2025 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлын хүрээнд эрүүл ахуй, орчин, хоол үйлдвэрлэл үйчилгээний бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын 23 сургууль, 40 цэцэрлэгүүдээр 2024 оны 08 дугаар сарын 25-31-ний өдрүүдэд 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж гарсан зөрчилд дутагдалд зөвлөмж хүргүүлэн ажилласан. | | |
| 5 | **Арга хэмжээ 2.5**<br>Багш, сурагчдын дунд дүүргийн аварга шалгаруулах олимпиадуудыг зохион байгуулна. | Арга хэмжээ, хамрагдах хүүхдийн тоо | 2 удаагийн олимпиадад 10,000 гаруй сурагчид хамрагдсан. | 1 | 2024-2025 оны хичээлийн жилд төрөлжсөн олимпиадыг 2024 оны 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 05-ны өдрүүдэд 13 төрөлд ерөнхий боловсролын 58 сургуулийн давхардсан тоогоор 37721 сурагч, 3 төрөлд ерөнхий боловсролын 48 сургуулийн 241 багш оролцож дүүргийн хэмжээний шилдгүүдээ тодруулж дурсгалын зүйлийг гардуулах ажлыг зохион байгуулсан. Шилдгээр шалгарсан багш, сурагчид дараагийн шатны төрөлжсөн олимпиадын бэлтгэлээ хангаж байна. | 2024.01.02-2024.12.02 | 100% |
| 6 | **Арга хэмжээ 2.6**<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна. | Хэрэгжсэн төсөл, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн тоо | 10 | 3 | Цахим танхим байгуулах, сургалтын техник хангамжийг нэмэгдүүлэх, EduTen, Pearson, LMS, SMS болон бусад цахим платформуудыг нэвтрүүлэх, багш сурагчдын цахим ур чадварыг хөгжүүлэх зэргээр бүхий л хэлбэрээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд сургууль, | 2024.01.02-2024.12.02 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цэцэрлэгүүд нөхөн хангалтын зардлаар цахим тоног төхөөрөмжийг худалдан авч байна. Цахим техник хангамжийг сайжруулахад Notebook-21, Tablet-52, PC-24 ширхэгийг худалдан авах, төсөл хөтөлбөрөөс хөрөнгө оруулалтыг хийсэн.<br>2019-2023 онд сургуулийн ном санд тараагдсан VI-XII ангийн 20103 сурах бичиг 42 сургуульд ашиглагдаж байна. Мөн 2024-2025 оны хичээлийн жилд ашиглах I-V ангийн 51537 ширхэг, VI-XII ангийн 11207 багц сурах бичгийн захиалгыг 60 сургуулиас авч Боловсролын ерөнхий газарт хүргүүлсэн.<br>"Зөв хүүхэд зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн хүрээнд Засаг даргын зөвлөлийн хурлаар 11 төслийг 201,5 сая төгрөгний санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Үүнд:<br>163 дугаар сургуулийн сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийн төсөл (15,9) сая төгрөг,<br>26 дугаар сургуулийн “Бага ангийн тохижилт” төсөл (19,9) сая төгрөг,<br>336 дугаар цэцэрлэгийн “Аз жаргалтай нямм нямм, гохх гохх” төсөл (19,8) сая төгрөг,<br>41 дүгээр цэцэрлэгийн “Шинэ үеийнхний сонирхолтой ертөнц” төсөл (18,0) сая төгрөг,<br>134 дүгээр цэцэрлэгийн “Соёлын үндэс” төсөл (19,9 ) сая төгрөг,<br>312 дугаар цэцэрлэгийн “Хайр түгээсэн халамжит өргөө” төсөл (18,0) сая төгрөг,<br>121 дүгээр цэцэрлэгийн “Ардын хөгжмийн зэмсгээр хүүхдийн хөгжлийг дэмжих” төсөл (14,6) сая төгрөг,<br>190 дүгээр цэцэрлэгийн гал тогоо, цахилгаан бараа нийлүүлэх төсөл (15,7) сая төгрөг,<br>290 дүгээр цэцэрлэгийн гал тогоо, цахилгаан бараа нийлүүлэх төсөл (16,0) сая төгрөг,<br>342 дугаар цэцэрлэгт гал тогоо туслах хэрэглэгдэхүүн нийлүүлэх төсөл (8,0) сая төгрөг,<br>59 дүгээр сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл (19,7) сая төгрөг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | **Арга хэмжээ 2.7**<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтад хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Боловсролын үйлчилгээнд хамрагдсан тусгай хэрэгцээт хүүхдийн тоо, зохион байгуулсан сургалтын тоо | Ерөнхий боловсролын 23 сургуулийн 520, сургуулийн өмнөх боловсролын 33 байгууллагад 160, нийт 680 хүүхдийг хамруулсан. | 2-оос доошгүй сургалтад 200 багш, сурагчийг хамруулна | 2023-2024 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 531, сургуулийн өмнөх боловсролд 256 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдаж байна.<br>"Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах үйлчилгээний загвар", "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багшийг чадавхжуулах, туршлага түгээн дэлгэрүүлэх, 6 удаагийн сургалтад сургууль, цэцэрлэгийн 83 багш, удирдлага,<br>Жайка старт 2 төсөл ерөнхий боловсролын 26, 34, 75 дугаар сургуулиуд,<br>"Ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй", "Ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр даунтай хүүхдийг хөгжүүлэх нь" сургалтад 10 багш,<br>"Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах-II" төслийн II шатанд 15, 118 дугаар сургууль, 218, 209, 46, 189 дүгээр цэцэрлэг,<br>Ерөнхий боловсролын 15, 34, 52 дугаар сургуульд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ангид туслах 3 багш ажиллаж байна. | 2024.01.02-2024.12.02 | 100% |
| Стратегийн зорилго 4. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, дэвшилтэт технологид суурилан түргэн шуурхай хүргэнэ. | | | | | | | |
| **Зорилт 3.** Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1**<br>Албан хэрэг хөтлөлтийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, ERP програмын хэрэглээг хэвшүүлэн иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд нь чанартай шийдвэрлэнэ. | Шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | 2024 оны жилийн эцэст албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системээр нийт 131 албан бичиг ирснийг судалж шийдвэрлэсэн. Харилцагч байгууллагууд руу 16 албан бичиг төлөвлөж хүргүүлсэн. | 2024.01.02-2024.12.02 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 3.2**<br>Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, баримт бичгийг боловсруулах, зохион байгуулах MNS5140:2011 стандартыг мөрдөн байгууллагын архивт хүлээлгэн өгнө. | Хүлээлгэн өгсөн хадгаламжийн нэгжийн тоо | 5 | 5 | Байгууллагын 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 15 хадгаламжийн нэгжийг архивын стандартын дагуу бүрдүүлж, архивт хүлээлгэн өгсөн. | 2024.01.02-2024.12.02 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | **Арга хэмжээ 3.3**<br>Ажлын цаг, цаг ашиглалтын зөрчилгүй ажиллана. | Цаг ашиглалтын хувь | 100% | 100% | Засаг даргын Тамгын газрын ажлын цаг ашиглалтын журмын дагуу зөрчил дутагдалгүй ажилласан. | 2024.01.02-2024.12.02 | 100% |
| 4. | **Арга хэмжээ 3.4**<br>Төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан мөрдөж ажиллана. | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг мөрдөж, **байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэн** иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхдээ төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чандлан мөрдөж ажилласан. | 2024.01.02-2024.12.02 | 100% |

**ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1. | "Хамтдаа алхаад эрүүлжье" явган алхалтыг зохион байгуулах | Арга хэмжээ, хамрагдах хүний тоо | - | 2 удаагийн арга хэмжээнд 500 хүнийг хамруулна | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан "Хамтдаа алхаад эрүүлжье" явган алхалтын удирдамж, хуваарийн дагуу 4 удаагийн явган алхалтыг тус дүүргийн 8 дугаар хороо, Жаргалантын аманд зохион байгуулсан. Явган алхалтад Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, иргэд нийт 1100 гаруй ажилтан алан хаагч, иргэдийг хамрагдсан. | 2024.01.02-2024.12.02 | 100 |
| 2.2 | Хүний хөгжил, нийгмийн салбарын байгууллагуудад дүүргийн Засаг даргын 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах ажлыг зохион байгуулна. | Арга хэмжээ, хамрагдах хүний тоо | - | 3 удаагийн арга хэмжээнд 1,000 хүнийг хамруулна | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ерөнхий боловсролын 23 сургуулийн 1801, сургуулийн өмнөх боловсролын 37 байгууллагын 1399 багш, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн 300 гаруй эмч, эмнэлгийн ажилтнуудыг хамруулан ажилласан. | 2024.02.05-2024.05.31 | 100 |
| 2.3 | "Мэргэжил бүхэн сайхан" аянг зохион байгуулна. | Арга хэмжээ, хамрагдах сурагчийн тоо | - | 10 удаагийн арга хэмжээнд 500 сурагчийг хамруулна | Хан-Уул дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Мэргэжил бүхэн сайхан" аянг 2024 оны 05 дугаар сарын 10-31-ний өдрүүдэд зохион байгуулсан.<br>Аяны хүрээнд Төрийн албан хаагчдын ажлын нэг өдөр, мэргэжлээ сонгосон түүх, мэргэжлийн онцлогийг | 2024.05.10-2024.05.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | судалж танилцан мэргэжлийн талаар асуулт тавьж сонирхолтой яриа өрнүүлж 12 удаа зохион байгуулж нийт 600 гаруй хүүхэд хамрагдсан. | | |
| 2.4 | "Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна. | Хамрагдах хүүхдийн тоо | - | 3000 доошгүй хүүхдийг хамруулна | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" хөтөлбөрийн хүрээнд "Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн нэгдсэн арга хэмжээг "Степпе арена"-ийн гадна талбайд зохион байгуулж 5000 орчим хүүхдүүд гэр бүлийнхээ хамтаар оролцсон. Хүүхдийн нас насны ангилалд хамаарах тоглоом наадгай, соёл урлаг, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, волейболын тэмцээн, шатар, даам, ширээний шагайн тэмцээн зэрэг хүүхэд, багачуудад зориулсан арга хэмжээнүүдийг батлагдсан хөтөлбөрийн дагуу хамтран зохион байгуулсан. | 2024.05.25-2024.06.01 | 100 |
| 2.5 | Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад зөөврийн компьютерийг гардуулан өгөх ажлыг зохион байгуулна. | Арга хэмжээ, хамрагдах хүний тоо | - | 500 доошгүй багшийг хамруулна | Хан-Уул дүүрэгт 2024 онд хэрэгжүүлж буй бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын онцлог ажлууд болон дүүргийн төсвийн хөрөнгөөр ерөнхий боловсролын 23 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 40 байгууллагуудад 2024 оны 09 дүгээр сарын 12-21-ний өдрүүдэд 841 ширхэг сүүлийн үеийн иж бүрэн зөөврийн компьютерийг багш нарт гардуулан өгөх ажлын зохион байгуулсан. | 2024.01.02-2024.12.02 | 100 |
| 2.6 | Хан-Уул дүүргийн өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах "Их нүүдэл" тэмцээнийг зохион байгуулна. | Хамрагдах сурагчийн тоо | - | 500 доошгүй сурагчийг хамруулна | Хан-Уул дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шатрын спортыг сурталчлах, шатрын спортоор хичээллэх сонирхлыг нэмэгдүүлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах **"ИХ НҮҮДЭЛ-2024"** тэмцээнийг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 75 дугаар сургуульд зохион байгуулсан.<br>Тус тэмцээнд төрийн болон төрийн бус өмчийн 27 сургуулийн 600 гаруй сурагч оролцож, оюун ухаанаа сорин өрсөлдсөнөөс 1-12 дугаар ангийн 72 сурагч шилдгээр | 2024.01.02-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгарч, батламж, алт, мөнгө, хүрэл медалийг гардуулах ажлыг зохион байгуулсан. | | |
| 2.7 | “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээг зохион байгуулна. | Хамрагдах сурагчийн тоо | - | 100 доошгүй сурагчийг хамруулна | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 24 сургуулийн 120 сурагчдад иргэний үнэмлэх, дурсгалын зүйлс гардуулах ажлын зохион байгуулсан. | 2024.01.02-2024.12.02 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.1**<br>Дээд шатны байгууллага болон Засаг даргын Тамгын газар, холбогдох сургалтын байгууллагаас зохион байгуулсан сургалтад идэвхтэй хамрагдана. | Хамрагдсан сургалтын тоо | 5 | 2 | Нийслэлийн Боловсролын газраас зохион байгуулсан "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах" сургалтад 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр хамрагдсан.<br>-Дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн” сургалтад 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хамрагдсан.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан “Бага насны хүүхдийн хөгжлийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ”-ний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх сургалтад 2024 оны 04 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд хамрагдсан. "Өргөдөл гомдлын системийн хэрэглээ" цахим сургалтад 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр хамрагдсан.<br>Эрүүл мэндийн яамнаас “Хүний папиллома вирусийн эсрэг вакцин нэвтрүүлэхэд шийдвэр гаргагч нарын оролцоо” сургалтад 2024 оны 06 дугаар14-ний өдөр хамрагдсан.<br>Монгол бичгийн цахим бичвэрийн сургалт 9 дүгээр сарын 18-ны өдөр хамрагдсан ,<br>“Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай журам, албан бичгийн стандарт, edoc | 2024.01.02-2024.12.02 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | системийн хөгжүүлэлт" сэдэвт сургалтад 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр хамрагдсан. | | |
| 2. | **Арга хэмжээ 1.2** Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан дүрэм, журмууд, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг танхим болон цахим хэлбэрээр судална. | Судалсан хууль, дүрмийн тоо | 3 | 2 | "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийг танилцуулах сургалтад 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хамрагдсан. Дижитал шилжилт виртуал орчинд ажиллах сургалтад 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хамрагдсан. Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцааны ур чадвар, манлайлал сургалтад 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хамрагдсан. | 2024.01.02-2024.12.02 | 100% |

**ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:**
БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.МӨНГӨНЧИМЭГ /............................ /

2024....12....02

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 5 дугаар хавсралт*

## НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. “Хамтдаа алхаад эрүүлжье” явган алхалтыг зохион байгуулах | Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Р.Цэвээндулам | хамрагдах хүний тоо | 500 | 1100 | 2024.03.30 | 2024.11.01 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Г.МӨНГӨНЧИМЭГ / ........................ / — 2024.12.02

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Р.ЦЭВЭЭНДУЛАМ / ........................ / — 2024.12.02

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Иргэдэд дүүргийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын талаарх тайланг танилцуулах арга хэмжээг зохион байгуулах | Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Р.Цэвээндулам | Хамрагдсан иргэдийн тоо | 1,000 | 3,500 | 2024.02.05 | 2024.05.31 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Г.МӨНГӨНЧИМЭГ / .......................... / — 2024.12.02

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Р.ЦЭВЭЭНДУЛАМ / .......................... / — 2024.12.02

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Мэргэжил бүхэн сайхан аян зохион байгуулах | Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Р.Цэвээндулам | Хамрагдсан сурагчдын тоо | 500 | 661 | 2024.05.10 | 2024.05.31 |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. "Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна. | Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Р.Цэвээндулам | Хамрагдах хүүхдийн тоо | 3,000 | 5,000 | 2024.05.20 | 2024.05.25 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Г.МӨНГӨНЧИМЭГ / ........................ / — 2024.12.02

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Р.ЦЭВЭЭНДУЛАМ / ........................ / — 2024.12.02

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| **Д/д** | **Үүрэг даалгавар** | **Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан** | **Шалгуур үзүүлэлт** | **Суурь түвшин** | **Хүрэх түвшин** | **Эхлэх хугацаа** | **Дуусах хугацаа** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад зөөврийн компьютерийг гардуулан өгөх ажлыг зохион байгуулна. | Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Р.Цэвээндулам | Хамрагдсан хүний тоо | 500 | 841 | 2024.09.12 | 2024.09.21 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.МӨНГӨНЧИМЭГ / ........................ / 2024.12.02

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Р.ЦЭВЭЭНДУЛАМ / ........................ / 2024.12.02

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*5 дугаар хавсралт*

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)**

| Д/д | Үүрэг даалгавар | Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. “Хан-Уул дүүргийн өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах “Их нүүдэл” тэмцээнийг зохион байгуулна. | Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Ариунжаргал | Хамрагдах сурагчийн тоо | 500 | 600 | 2024.10.20 | 2024.10.24 |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээг зохион байгуулна. | | Хамрагдах сурагчийн тоо | 100 | 120 | 2024.11.20 | 2024.11.22 |

**НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.МӨНГӨНЧИМЭГ / ........................ / 2024.12.02

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.АРИУНЖАРГАЛ / ........................ / 2024-12-02

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ГЭСЭРМААГИЙН МӨНГӨНЧИМЭГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Нийгмийн хөгжлийн хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж , дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1.** Боловсролын салбарын хууль тогтоомж, төрөөс баримталж буй бодлого, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, тайлагнах. | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. | 40 | 10 | 50 | |
| 2. | Арга хэмжээ 1.2. | 45 | 10 | 55 | |
| 3. | Арга хэмжээ 1.3. | 55 | 10 | 65 | |
| **Зорилт 2.** Боловсролын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, хяналт тавих. | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 2.2. | 58 | 10 | 68 | |
| 3. | Арга хэмжээ 2.3. | 55 | 10 | 65 | |
| 4. | Арга хэмжээ 2.4. | 58 | 10 | 58 | |
| 5. | Арга хэмжээ 2.5. | 60 | 10 | 70 | |
| 6. | Арга хэмжээ 2.6. | 50 | 10 | 60 | |
| 7. | Арга хэмжээ 2.7. | 50 | 10. | 60. | |
| **Зорилт 3.** Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Арга хэмжээ 3.2. | 60 | 10 | 70 | |
| 3. | Арга хэмжээ 3.3. | 50 | 10 | 60 | |
| 4. | Арга хэмжээ 3.4. | 60 | 10 | 70. | |
| Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт | | | | | |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. | 60 | 10 | 70 | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. | 60 | 10 | 70 | |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. | 60 | 10 | 70 | |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. | 60 | 10 | 70 | |
| 5 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. | 60 | 10 | 70 | |
| 6 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. | 60 | 10 | 70 | |
| 7 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1. | | | |
| 2. | Арга хэмжээ 2. | | | |
| **Дундаж оноо** | | | | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 8 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(70 хүртэлх оноо)* 66,7 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* 11 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(7 хүртэлх оноо)* 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | (92,7 оноо) |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | |

***Үнэлгээ өгсөн:***

Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ /Ч.АРИУНЖАРГАЛ/

2024.12.02 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн ........................ /Г.МӨНГӨНЧИМЭГ/

2024.12.02 (огноо)

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга ........................ /Л.ОТГОНБАЯР/

2024.12.13 (огноо)

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

Хүний нөөц, хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан ахлах мэргэжилтэн ........................ /Б.САРАНЦАЦРАЛ/

2024.12.13 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч***

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ /З.БУЯНТ/

2024.12.12 (огноо)